

Элизабет Энскомб. Орчин үеийн ёс суртахууны философи¹⁶⁹

Орчуулсан: Э.Баасандорж, магистр, багш
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Би уг өгүүллээр үзүүлэх гурван сэдвээ мэдэгдэхээс эхэлье. Нэгдүгээрт, өнөө үед бидэнд ёс суртахууны философидолт ашиггүй; бид зохих сэтгэл судлалын философийг хөгжүүлэх хүртлээ үүнийг хажуу тийш нь тавих хэрэгтэй бөгөөд уг сэтгэл судлалын философи бидэнд дутагдаж байгаа нь илэрхий юм. Хоёрдугаарт, алба үүрэг, үүрэг —өөрөөр хэлбэл, *ёс суртахууны* алба үүрэг ба *ёс суртахууны* үүрэг— хийгээд *ёс суртахууны хувьд* буруу, зөвийн талаарх ойлголтууд, “ёстой” хэмээхийн *ёс суртахууны* утгыг, хэрэв сэтгэл судлалын хувьд боломжтой бол, орхих учиртай; учир нь энэ ойлголтууд түрүү үеийн ёс зүйн талаарх ойлгоцоос үлдэж хоцорсон, эсвэл үлдэж хоцорсон зүйлсээс урган гарсан зүйлс бөгөөд тэрхүү ойлгоц нь өнөө үед ерөнхийдөө бол байхгүй. Эдгээр нь тэрхүү ойлгоцгүй бол бидэнд балаг л авчрахаас хэтрэхгүй. Дэвшүүлэх гуравдугаар сэдэв маань Сижвикээс (Sidgwick) эхлээд өнөө үе хүртэлх ёс суртахууны философийн тухай авч үзсэн алдартай Англи зохиогчдын дунд буй ялгаа тийм чухал биш тухайд болно.

Аристотелийн *Ёс Зүй* хийгээд орчин үеийн ёс суртахууны философийг уншсан хэн ч бай энэ хоёрын дундах үлэмж эсрэгцлийг гайхах болно. Орчин үеийнхний дунд алдартай нэр томъёонууд Аристотельд байхгүй эсвэл ямар нэг байдлаар булагдсан, нэг бол дэвсгэр болж бүдэгхэн үлдсэн мэт санагдана. Хамгийн тод жишээ нь, бидний Аристотелиос шууд өвлөн авсан “ёс суртахууны” гэх нэр томъёо өөрөө бол орчин үеийн утгаараа, Аристотелийн ёс зүйн баримтлалд үл нийцэх ажээ. Аристотель эрхэм чанаруудыг (virtues) ёс суртахууны хийгээд оюуны хэмээн ялгасан. Түүний “оюуны” хэмээн нэрлэсэн зарим эрхэм чанаруудад *бидний* “ёс суртахууны” гэж болох тал бий юу? Тийм мэт харагдаж байгаа; шалгуурыг нь харвал “оюуны” эрхэм чанарын хувьд —жишээ нь, хотын захиргаанд, тустай зүйл авчрах тухайд тооцоолохдоо сайн шийдэмж гаргах— бүтэлгүйтэх явдал нь *зэмлэвэл зохих* зүйл байж болдог гэдэгт байгаа бололтой. Гэвч —учиртайгаар ийн асууж болно— *ямар ч* бүтэлгүйтэл буруутгагдах эсвэл зэмлүүлэх асуудал болохгүй юу? Ямар ч гутаасан шүүмжийг, жишээ нь бүтээгдэхүүний ур хийц эсвэл машины загварыг гутаасан шүүмжийг зэмлэл эсвэл буруутгал хэмээж болно. Иймд бид дахиад л “ёс суртахууны” гэх үгийг оруулж ирэх болно: заримдаа тийм бүтэлгүйтэл нь *ёс суртахууны* үүднээс зэмлүүлбэл зохилтой байх бөгөөд заримдаа тийм биш байна. Харин Аристотельд ёс суртахууны зэмийн талаарх өөр бусдаасаа ялгаатай санаа байсан уу? Хэрэв түүнд байсан гэвэл, тэр нь яагаад илүү төвд байсангүй вэ? Тэр үйлдлийн санаатай бус шинж (involuntariness) биш харин өөдгүй зангийн (scoundrelism) шалтгаан болж хүнийг буруутгагдахад хүргэдэг алдаа бий гэжээ. Энэ нь оюуны хувьд тодорхой алдаа гаргахгүй байх *ёс суртахууны* алба үүрэг (obligation) байдаг гэсэн үг үү? Тэр яагаад алба үүргийн талаар ерөнхийд нь яриад, уг алба үүргийн талаар тухайлан өгүүлсэнгүй вэ? Хэрэв хэн нэг хүн Аристотелийг өргөжүүлж, “ёс суртахууны” гэдгийн тухайд орчин үеийн хэв маягаар төрөл бүрийн зүйл ярьж байгаагаа хүлээж байгаа бол, уг хүн өөрийгөө эрүү нь ямар нэг байдлаар буруу хэлбэрт орсон хүн шигээр байн байн мэдрэхгүй байгаа гэвэл (шүд нь зөв зуугддаггүй), уг хүн тун мэдрэмжгүй нэгэн байж таарна.

Тэгэхээр Аристотелиос “ёс суртахууны” сайн чанар хийгээд алба үүрэг гэх мэт зүйлсийн талаарх орчин үеийн ярианы ямар ч илрэлийг олж харж чадахгүй. Түүнчлэн, Батлераас эхлээд Милл хүртэл орчин цагт ёс зүйн тухай бичдэг хамгийн алдартай улс бүгдээрээ надад энэ сэдвийн

¹⁶⁹ Уг өгүүллийг анх Оксфордод, Волтейрийн Нийгэмлэгт уншиж танилцуулсан.

тухайд авч үзэхдээ алдсан шиг харагдаж байгаа бөгөөд уг сэдвийг шууд гийгүүлэх зүйлийг тэднээс олно гэж найдах боломжгүй болгож байгаа юм. Би энэ эсэргүүцлээ богинохон мэдэгдэнэ.

Батлер мөс чанарыг (conscience) өргөмжилдөг ч, мөс чанар аливаа хүнд хамгийн булай зүйл хийхийг хэлдэг гэдгийг үл хэрэгссэн шиг байдаг.

Хьюм “үнэн” гэдгийг ёс зүйн шийдэмжүүдийг (judgment) үл хамруулах байдлаар тодорхойлж, эдгээрийг тийн үл хамаардгийг нотоллоо хэмээдэг. Тэр бас “дур хүсэл” (passion) гэдгийг туйлын байдлаар, ямар нэг зүйлд чиглэж зорих явдал үргэлж дур хүсэлтэй байх явдал байдаг хэмээн тодорхойлжээ. “Бол” гэдгээс “ёстой” гэдэгт хүрэх тухайд хандсан түүний эсэргүүцэл “бол” гэдгээс “өртэй” (owes) гэдэгт эсвэл “бол” гэдгээс “хэрэгтэй” гэдэгт хүрэх явдалд ч бас үйлчилнэ. (Гэхдээ, түүхэн нөхцөл байдлаас болоод, түүнээс авах санаа бий бөгөөд үүнийг би сүүлд эргэн авч үзнэ.)

Кант “өөрөө өөртөө хууль өгөх” тухай санааг танилцуулсан. Энэ нь олонхын санал илүү хүндэтгэл хүлээдэг өнөө үед, хүний хийсэн тунгаамал шийдвэр (reflective decision) бүрийг олонхын саналын үр дүн буюу, үргэлж 1-0 байх гайхмаар харьцаанаас бий болох хэрэг хэмээн үзэхтэй ижил утгагүй хэрэг юм. Хууль тогтоох тухай ойлголтод хууль тогтоогчийн тал дахь давуу хүч шаардлагатай. Худал ярих талаарх түүний өөрийнх нь нарийн чанд үнэмшил нь, тэр худал ярих гэдгийг хэзээ ч зүгээр л худал гэдгээс өөр ямар ч байдлаар (жишээ нь, “тийм тийм нөхцөлд худал ярих” гэдэгтэй ижлээр) зохистой дүрслэх аргагүй хэмээн үзэж байсан мэт санагдахаар тийм хүчтэй байв. Аливаа үйлдлийн талаар максим босгох зорилго өөд харж байгаа үед юу тухайн үйлдэлд зохих дүрслэл болох тухайд хандсан болзолгүй бол түгээмэлчилж болох максимын талаарх түүний дүрэм ашиггүй.

Бентам, Милл нар “Таашаал” гэх ойлголтын хүндрэлийг анзаарсангүй. Тэднийг “натуралист алдаа”-г (naturalist fallacy) чандлан баримталснаараа алдсан гэх шүүмж нийтлэг байдаг; гэвч энэ буруутгал надад хүчтэй сэтгэгдэл төрүүлдэггүй, учир нь эдгээрийн тайлбарууд надад авцалдаатай санагддаггүй. Харин нөгөө нэг санаа нь —таашаалын талаарх— надад бүр эхнээсээ л сүрхий шүүмж шиг санагдсан.

Эртний үеийнхэнд уг ойлголт нэлээд бэрх санагдаж байжээ. Энэ нь Аристотелийг “залуу хүний улаа бутарсан хацар”-ны тухайд аяархан бувтнахад хүргэжээ. Учир нь, хангалттай сайн учир шалтгааны үүднээс, тэр үүнийг тааламжит үйл ажиллагаанаас өөр бас нэгэн зэрэг түүнтэй адил болгох гэжээ. Орчин үеийн философичдын бүтэн үе уг ойлголтыг энгийн хялбар мэт үзэж, нэг хоёр жилийн өмнөөс Райл уг сэдвээр бичих болсноор л энэ эргэн төвөгтэй асуудал болж гарч ирэв. Үүний учир шалтгаан тун энгийн: Локкоос хойш, таашаалыг ямар нэг дотоод сэтгэгдэл хэмээн үзэх болсон. Гэвч энэ нь таашаалын талаарх зөв баримтлал байсан бол үүнийг үйлдлийн чиглэл болгох нь өнгөц авч үзсэн хэрэг байв. Аливаа хүн “утга”-ын тухай Виттгенштейний хэлсэн нэг зүйлийг хүлээн аваад, “Таашаал аваас дотоод сэтгэгдэл байж таарахгүй, учир нь ямар ч дотоод сэтгэгдлийн үр дагавар нь таашаал байж чадахгүй” хэмээж болно.

Милл бас Кантын адилаар, хэрэв онол нь агуулгатай байна гэвэл, тохирох дүрслэлүүдийг болзол болгохын зайлшгүй шаардлагыг ухаарсангүй. Түүнд аллага хийгээд хулгай хийх үйлдлүүдийг өөрөөр дүрслэх боломжтой мэт санагдаагүй.

Тэр авч үзэж буй аливаа үйлдэл нь ашигт байдлын (utility) суурь дээр босгосон зарчмын дор орж таарах тийм төрөлд хамаарах бол, хүн түүний дагуу явах ёстой гэж үздэг; энэ хэд хэдэн зарчмын дор нэг зэрэг орж эсвэл алиных нь ч дор орохгүй байгаа үед, хэд хэдэн зарчмын дор орж байгаа нь тухайн үйлдлийн талаарх зөрчилт үзлүүд байгааг илтгэнэ, ийм үед тухайлсан үр дагавруудыг тооцоолох нь зүйтэй. Гэвч ямар ч үйлдэл ашигт байдлын ямар нэг зарчим дор орж байгаа л бол түүнийг ашигт байдлын өөр өөр зарчмууд дор ордог хэмээн дүрслэхэд тийм ч төвөгтэй биш (миний товчхон хэлж байгаачлан).

Одоо би Хьюм рүү эргэе. Миний өмнө дурдсан Хьюмийн философид хамаарах шинжүүд нь үүний өөр олон бусад шинжийн адилаар, Хьюмийг —гялалзсан— софист л байжээ хэмээн үзэхэд хүргэж байна; бас түүний үйл ажиллагаа яах аргагүй софист шинжтэй. Гэвч би Хьюмийн философидолтын этгээд өвөрмөц байдлаар энэ шийдэмжээс буцаах биш харин үүн дээр нэмэхээс аргагүйд хүрч байна: тодруулбал, тэр софист шинжтэй арга хэрэглэн —хайртай байсан— дүгнэлтүүддээ хүрсэн хэдий ч, түүний ач холбогдол өгч байсан зүйлс маш гүн бас чухал асуудлуудыг нээж гаргадаг. Хүн софист байдал гаргах үйлдэл дундаа маш их эрэл хайгуул хэрэгтэй асуудлуудыг анзаарч байгаагаа ухаарах нь олонтой тохиолдоно: Хьюмийн гаргасан мэт харагдаж буй санаануудын үр дүнд хийх хэрэгтэй болсон судалгаа шинжилгээ үүний илэрхий жишээ мөн. Энэ талаараа тэр Батлераас ялгаатай. Түүний үед мөс чанар (conscience) тухайн хүнийг хамгийн булай зүйлд чиглүүлж байж болно гэдгийг хүмүүс сайн мэддэг болсон байв; Батлерын хувьд үүнийг үл хэрэгсэн бичсэн гэдэг нь бидэнд ямар ч шинэ сэдвийг нээн өгөхгүй. Харин Хьюмийн хувьд бол энэ өөр: учир нь түүний софист байдлыг үл тооцвол, тэр машид төгөлдөр, агуу философич мөн. Жишээ нь:

Би хүнсний ногоо нийлүүлэгчдээ “Үнэн нь 20s = £1” гэх мэт санаануудын харилцаанаас, эсвэл би төмс захиалсан, чи түүнийг нийлүүлсэн, тэгээд над руу тооцооны баримтаа явуулсан гэх мэт баримтаас тогтдог. Тэгэхээр үнэн гэдэг нь би ийм хэмжээний өртэй гэх хэллэгт хамаарахгүй” гэж хэлсэн хэмээн үзье.

Хэрэв ийн харьцуулбал, “Х нь Y-д тийм хэмжээний өртэй” гэх дүрслэлд дурдагдаж буй баримтуудын харилцаа бидний сонирхлыг татах бөгөөд би үүнийг тухайн дүрслэлд “харьцангуйгаар үл тайлбарлагдах шинжтэй” (brute relative) байх явдал хэмээнэ. Цаашлаад, энд дурдсан “үл тайлбарлагдах” баримтуудад өөрсдөд нь өөр баримтуудад харьцангуйгаар “үл тайлбарлагдах шинжтэй” байх дүрслэлүүд бий —жишээ нь, *тэр манай гэрт төмс зөөж авчирсан* бас *төмс тэндээ үлдсэн* зэрэг нь “тэр надад төмс нийлүүлсэн” гэдэгт харьцангуй үл тайлбарлагдах баримт болох шиг. Бас Х нь Y-д өртэй гэдэг нь эргээд өөр дүрслэлүүдэд харьцангуй “үл тайлбарлагдах шинжтэй” (brute) байна. —Жишээ нь, “Х нь төлбөрийн чадамжтай.” Одоо “харьцангуй үл тайлбарлагдах шинж”-ийн харилцаа нь төвөгтэй эд болж таарлаа. Цөөн хэдэн санаа дурдахад: хэрэв хуз гэдэг нь А дүрслэлд харьцангуйгаар үл тайлбарлагдах баримтуудын олонлог бол, хуз нь А-г багтааж байх олонлогийн хүрээнээс гадна байх ямар нэг олонлог болно; гэвч эдгээрийн дунд ямар нэг олонлог багтах явдлаас А зайлшгүй байдлаар урган гарахгүй, учир нь онцгой тохиолдлууд дээрхийг өөрчлөх боломж ямагт бий; А-д харьцангуй байх онцгой тохиолдлууд ямар өөрчлөлт оруулж чадахыг цөөн хэдэн ялгаатай жишээ гаргаж тайлбарлах л боломж бий, ямар ч онцгой хам нөхцөлийг дахин тайлбарлах дараагийн онцгой хам нөхцөлийг онолын хувьд ямагт төсөөлж болох учраас, онцгой нөхцөл байдлыг онолын шинжтэйгээр урьдаас бүрэн тооцоолох арга үгүй. Түүгээр үл баран, жирийн нөхцөл байдалд ч, хуз нь А-ын зөвтгөл болно гэдэг бол А нь “хуз”-тэй зүгээр л ижил болж таарна гэсэн үг биш; бас санаагаа дүрслэл А-д өгөх институтцийн шинжтэй хам нөхцөл байх талтай бөгөөд, энд институтц А нь өөрөө дүрслэл байхгүй гэдэг нь мэдээж хэрэг юм. (Жишээ нь, би хэн нэг хүнд шиллинг өгсөн гэх бодомж бол энэ улсын мөнгөн дэвсгэрт эсвэл мөнгө гэдэг институтцийн дүрслэл биш юм.) Иймд, жишээ нь, “бол” гэдгээс “өртэй” гэдэгт чиглэсэн шилжилт огтоос байхгүй мэт дүр эсгэх нь инээдтэй хэрэг болно. Уг шилжилтийн онцлог шинж нь үнэн хэрэгтээ тун сонирхолтой бөгөөд Хьюмийн үндэслэлийг тунгаасны дүнд ил болно.¹⁷⁰

Би ногоо нийлүүлэгчдээ тийм үнэн дүнгийн өртэй гэдэг нь “би бол мэхлэгч” гэх дүрслэлд холбогдох харьцаагаараа “үл тайлбарлагдах шинжтэй” байх хэсэг бүлэг баримтуудын нэг болно.

¹⁷⁰ Дээрх хоёр цогцолбор нь *Анализ* сэтгүүлийн ирэх дугаарт нийтлэгдэх “Үл тайлбарлагдах Баримтуудын Тухайд” (On Brute Facts) хэмээх өгүүллийн хураангуй (abstract) болно.

“Мэхлэх” гэдэг бол “үнэнч шударга бус” эсвэл “зүй бус” гэх мэт төрөлд орох нь мэдээж. (Ерийндөө бол би зүй бус (injustice) үйлдэл хийх эсвэл түүнээс зайлсхийхийг хүсээгүй л бол дан ганц бодож үзэх нь миний үйлдэлд нөлөөгүй.)

Энэ хүртэл, хоорондын хүчтэй холбоосоос нь үл хамааран, би “мэхлэлт,” “зүй бус байдал” болон “үнэнч шударга бус байдал” зэргийг зүгээр л “баримтын” арга замаар авч үзлээ. Би “мэхлэлт” гэдгийг тийн авч үзэж болно гэдэг нь хангалттай тодорхой хэрэг юм; “зүй ёс” гэдгийг бол би өөр бусад хүмүүстэй холбогдох үйлдлүүдийг хамардаг гэдгээс өөрөөр тодорхойлох санаа алга, харин үүнд гарсан доголдол буюу “зүй бус байдал”-ыг одоохондоо янз бүрийн төрлийг хамарсан ерөнхий нэр болгон хэлж болох юм. Жишээ нь: “мэхлэлт,” “хулгай” (аль ч өмчийн институт оршиж байгаагаас харьцангуйгаар), “завхайрах,” “гэмгүй нэгний шийтгэх” гэх мэт.

Өнөөгийн философид зүй бус хүн хэрхэн муу хүн гэж тооцогдох, эсвэл зүй бус үйлдэл муу үйлдэл болох талаар тайлбар шаардлагатай; тийм тайлбар хийх ажил нь ёс зүйн салбарт хамаарна; гэвч бид сайн үндэслэл бүхий сэтгэл судлалын философиор тоноглохоос нааш уг ажлыг эхлүүлж чадахгүй. Учир нь зүй бус хүн бол муу хүн гэх нотолгоо нь зүй ёсыг “эрхэм чанар” (virtue) хэмээн үзэх эерэг баримтлалыг шаардах болно. Гэхдээ, ёс зүйн судлах асуудал болж буй энэ хэсэг нь биднийг эрхэм чанар гэдэг нь ямар хэв шинж бүхий онцлог чанартайг — энэ нь ёс зүйн бус харин ойлголтын задлан шинжилгээний асуудал — бас энэ нь хамаарч буй үйлдлүүдтэйгээ ямар холбоотой талаарх баримтлалтай болохоос нааш бүрэн хаалттай байх юм: Энэ асуудлыг Аристотель тодорхой болгож дөнгөөгүй гэж би бодож байна. Ингэхийн тулд бидэнд, наанадаж, хүний үйлдэл ерөөс юу болох талаар бас “тийм-тийм зүйл хийх” гэх мэт үүний дүрслэл нь хэрхэн өөртөө буй сэдэл болон сэдэмж эсвэл сэдэмжүүдийн нөлөөнд ордог талаарх баримтлал хэрэгтэй гэдэг нь гарцаагүй; харин тийм баримтлалтай болоход бидэнд дээрх ойлголтууд шаардлагатай. “Зохилтой” эсвэл “ёстой” нэг бол “хэрэгтэй” гэх мэт нэр томъёонууд сайн бас муу гэдэгтэй холбоотой: жишээ нь, машин механизмыг тослох хэрэгтэй, эсвэл тослох нь зохилтой, тослох ёстой, учир нь тосгүй ажиллах нь үүнд муу эсвэл тосгүй бол энэ муу ажилладаг. Энэ ойлгоцын дагуу бол, “зохилтой” хийгээд “ёстой” гэх ойлголтуудыг хүн бусдыг мэхлэх нь зохихгүй гэж хэлэхэд гардаг шиг “ёс суртахууны” өвөрмөц утгаар хэрэглээгүй байгаа нь мэдээж хэрэг билээ. (“Ёс суртахууны” (*ηθικός*) гэдэг нь Аристотелийн авч үзсэн үүднээс харах юм бол дээрх ойлголтууд ёс суртахууны сэдэвтэй холбоотойгоор хэрэглэгдсэн бий.) Гэвч өнөө бол эдгээр нь “ёс суртахууны” гэгдэх өвөрмөц утгат чанарыг олсон — өөрөөр хэлбэл, тодорхой хэв шинж бүхий хам сэдвийн хүрээнд хэрэглэж буй “ёстой” гэх үг бүхий өгүүлбэрүүдэд дүрслэгдсэн зүйлийн тухайд ямар нэг туйлын шинжтэй тангарагтны шүүхийн шийдвэрийг (аливаа хүн хэн нэгний өмнө гэм буруутай/гэм буруугүй гэдэг шиг) илэрхийлсэн утгат чанарыг: Аристотелийн “ёс суртахууны” — дур хүсэл болон үйлдэл — гэж дуудах байсан хам сэдвүүд биш давхар түүний “оюуны” хэмээн дуудах байсан зарим хам сэдэв.

“Зохилтой,” “хэрэгтэй,” “ёстой,” “учиртай” гэх мэт ердийн (бас нэлээд чухал) нэр томъёонууд — тодорхой хам сэдвийн хүрээнд “албатай,” (is obliged) эсвэл “баригдсан” (is bound), “шаардлагатай,” (is required to) зэргийн хүн хуулиар хязгаарлагдсан эсвэл хуулийн үүднээс ямар нэг зүйл шаардлагатай гэх мэт утгат чанартай тэнцэтгэгдсэнээр мөнөөх өвөрмөц утгат чанарыг олж авсан.

Хэрхэн ийм зүйл болов? Хариулт нь түүхэнд бий: Аристотель болон бидний дунд Христийн шашин ёс зүйг хууль гэх ойлгоцтойгоо байв. Христийн шашны хувьд ёс зүйн ухагдахуунуудаа Торагаас авсан. (Эерэг тэнгэрлэг хууль байгаа гэж үздэг хүмүүсийн дундаас л ёс зүйг хууль гэх ойлгоц гарч ирж болно хэмээн бодоход хүрч болох юм; гэхдээ тийм биш гэдгийг бид Стойкууд буюу хүний эрхэм чанарт нийцэх бүхэн тэнгэрлэг хуулийн шаардлага байдаг хэмээн үзэж байсан хүмүүсийн жишээнээс үзэж болно.)

Христийн шашин олон зууны турш ноёлсны үр дүнд, баригдсан, зөвшөөрөгдсөн, эсвэл хэлтрүүлэгдсэн зэрэг ойлголтууд бидний хэл ба сэтгэлгээнд гүн шигджээ. Грекийн *αμαρτάνω* буюу тийм хэрэглээнд орох хамгийн өндөр хандлагатай үг “алдаа,” “хазайх,” “буруудах,” зэрэг утгаас өөрчлөгдөж “нүгэл” гэх утгат чанарыг олж авсан байна. Латин хэлний *peccatum* буюу *αμαρτία* гэдэгт дөхөх утга бүхий үг “culpa” — “гэм” — буюу тангарагтны шүүхийн ухагдахуунтай холбоотой байсан учраас “нүгэл” гэх утгат чанарыг олж авахад бүр ч амар байв. “Цээртэй,” “хуульд харш” гэх мэт цулгүй нэр томъёо бидний “буруу” гэх цулгүй нэр томъёотой маш адилхан утгатай нь өөрөө өөрийгөө тайлбарлана. Аритотельд тийм цулгүй нэр томъёо байгаагүй нь хачирхалтай. Түүнд хорон муу байдлыг (wickedness) илэрхийлэх цулгүй нэр томъёонууд байсан — “хорон санаатан,” (villain) “өөдгүй этгээд” (scoundrel); гэхдээ хүн нэг эсвэл цөөн хэдэн муу үйлдлээс болоод хорон санаатан эсвэл өөдгүй этгээд болохгүй нь мэдээж. Бас түүнд “мундартай,” (disgraceful) “сүсэг бишрэлгүй” (impious) гэх мэт нэр томъёонууд байсан; түүнчлэн, “хуурмаг” гэх мэт тодорхой нэг эрхэм чанарын доголдлыг тэмдэглэх тухайлсан нэр томъёонууд байсан; харин “цээртэй” гэдэгт харгалзах нэр томъёо байсангүй. Энэ нэр томъёоны багтаамж нь (өөрөөр хэлбэл энэ үгийг хэрэглэх хүрээ нь) түүний томъёоллоор бол нэлээд урт өгүүлбэрт илэрхийлэгдэнэ:

“Цээртэй” (illicit) гэдэг бол, бодсон эсвэл дур хүсэл эсвэл үйлдлийг зөвшөөрсөн нэг бол бодол эсвэл үйлдэлдээ орхисон эсэхээс үл хамааран, хэрэв байхгүй бол тухайн хүн хүн *болохынхоо хувьд* (qua) муу гэдгийг харуулах эрхэм чанаруудын аль нэгтэй эсрэгцэх зүйл юм. Энэ томъёолол “цээртэй” гэх ойлголттой адил-багтаамжтай ойлголтыг тээж байгаа.

Ёс зүйг хууль гэх ойлгоцтой байна гэдэг бол хүнийг хүн *болохынхоо хувьд* (зүгээр л гар урлаач эсвэл логикч болохынхоо хувьд биш) муу болохыг илтгэх тэмдэг буюу эрхэм чанарын доголдолтой нийцэхэд хэрэгтэй зүйлийг барьж байна гэсэн үг — үүнд хэрэгтэй зүйлийг тэнгэрлэг хууль шаарддаг гэх. Угтаа бол Эзэн Тэнгэрийг хууль тогтоогч хэмээн итгэдэггүй л бол тийм ойлгоцтой байх боломжгүй юм; Еврей шашинтнууд, Стойкууд, Христийн шашинтнууд шиг. Гэхдээ тийм ойлгоц олон зууны турш давамгайл байж ирсэн бол, тэгээд тийм байхаа больсон бол, “алба үүрэг” гэх мэт хуульд баригдсан эсвэл хуулийн шаардлагын ойлголтууд үндсээ алдсан хэдий ч хадгалагдаж үлдэх нь хэвийн үзэгдэл мөн; бас “ёстой” гэх үг тодорхой хам нөхцөлүүдэд “алба үүрэг” гэх утгат чанараар орох болсон бол, энэ ч мөн адил тэрхүү хам сэдвийнхээ хүрээнд өвөрмөц өргөлт, өвөрмөц мэдрэмжтэйгээр хэлэгдэх болно.

Энэ нь эрүүгийн хууль, шүүх татан буугдаж, мартагдсан үед ч “гэмт хэрэгтэн” гэх ухагдахуун үлдэж хоцрохтой ижил юм. Хьюм ийм нөхцөл байдлыг нээж илрүүлэхдээ “гэмт хэрэгтэн” гэх үгэнд утгат чанарыг нь дангаараа өгөх бас энэ үгээр илэрхийлэгдэх өвөрмөц сэтгэл мэдрэмж байна хэмээн дүгнэх байсан болов уу. Тэгэхээр, Хьюм “алба үүрэг” гэх ухагдахуун үлдэж хоцорсон, “ёстой” гэх ухагдахуунд “ёс суртахууны” утгат чанарт хэрэглэгдэж байсан гэх мөнөөх онцгой хүчин орсон боловч тэнгэрлэг хуульд хандсан итгэл үнэмшлийг аль эрт орхисон нөхцөл байдлыг нээн илрүүлжээ: учир нь Шашны шинэтгэлийн үед уг ойлголтыг Протестантууд угаар нь авч орхисон байв.¹⁷¹ Хэрэв миний зөв бол, энэ нөхцөл байдал бол аливаа ойлголт өөрийг нь ухварлагдахуйц (intelligible) болгож байсан сэтгэлгээний хүрээнээс гадна тогтож үлдсэн сонирхолтой хэрэг байв.

¹⁷¹ Тэд тэнгэрлэг хууль байдлыг үгүйсгээгүй; гэвч тэдний хамгийн гол, онцлог номлол нь үүнийг хүмүүс, нигүүлслээр байсан ч, мөрдөж чадахгүй гэдгийг харуулахын тулд хүмүүст ийм хууль өгснөөс биш мөрдүүлэхийн тулд өгөөгүй гэх санаа юм; бас энэ нь Торагаас салаалж гарсан заавруудад л зөвхөн хамаатай биш бөгөөд “натурал тэнгэрлэг хууль”-ийн шаардлагад ч бас хамаатай гэдэг. Христийг эвлэрүүлэгч болохынх нь хувьд л итгэхээс биш, түүнийг хууль тогтоогч мэтээр дагахгүй байх сургаалын эсрэг Трентийн тогтоолтой харьцуулж үзнэ.

Хьюм, тэгэхээр, “бол” гэдгээс “ёстой” гэдэг рүү шилжих явдлын тухай алдарт тайлбараа боловсруулахдаа хоорондоо нэлээд ялгаатай хэд хэдэн санааг нэгтгэсэн. Эдгээрээс нэгийг нь би “бол” гэдгээс “өртэй” гэдэг рүү хийх шилжилт болон баримтуудын харьцангуй “үл тайлбарлагдах шинж”-ийн тухай хийсэн тайлбартаа гаргаж ирэхийг оролдсон. “Бол” гэдгээс “хэрэгтэй” гэдэг рүү хийх шилжилтийг шинжиж үзээд өөр санаа гаргаж ирэх боломжтой; жишээ нь, амьд биетийн онцлог шинжээс тухайн амьд биетэд хэрэгтэй орчин нөхцөлийг гаргаж ирж болно. Тухайн амьд биетэд аливаа нэг орчин нөхцөл хэрэгтэй гэж хэлэх явдал бол, жишээ нь, тухайн амьтныг тэрхүү орчин байлгахыг хүсэж байна гэж хэлж байгаа хэрэг биш, харин тэрхүү амьд биет уг орчинд байхгүй бол хөгжин цэцэглэж (flourish) чадахгүй гэж хэлж байгаа хэрэг юм. Энэ нь, Хьюмийн хэлэх байсанчлан, та уг амьд биетийг хөгжин цэцэглүүлэхийг хүсэх эсэхээс бүхэлдээ хамаарах асуудал гэдэг нь мэдээж! Гэвч, тухайн амьд биетийг хөгжин цэцэглүүлэхийг хүсэх эсэхээс “бүхэлдээ хамаарах” зүйл гэвэл тухайн амьд биетэд уг орчин нөхцөл хэрэгтэй, үүнгүйгээр тэр хөгжин цэцэглэж чадахгүй гэдэг баримт таны үйлдэлд өчүүхэн ч болов нөлөө үзүүлэх эсэх явдал юм. Одоо тийм-тийм зүйлс байх “ёстой” эсвэл “хэрэгтэй” гэдэг нь үйлдэлд нөлөөтэй байдаг хэмээн үзэж таарах нь: үүнээс “байх ёстой” гэж шүүн шийдэх (judge) үнэн хэрэгтэй “байх ёстой” хэмээн шүүн шийдсэн зүйлээ үйлдэлдээ нөлөөлөхийг зөвшөөрч буй явдал гэдэг гаргалгаа хийх нь хэвийн л зүйл мэт харагджээ. Бас байгаа зүйлсийн талаарх ямар ч хэмжээний үнэн байсан хүний үйлдэлд нөлөөлдөг гэх логик баталгаа байх боломжгүй. (Тийм шийдэмж (judgement) өөрөө бидний хөдөлгөөнд оруулж буй юм биш; харин хүсэж буй зүйлээ хэрхэн авах эсвэл хийх тухайд хандсан шийдэмж маань биднийг хөдөлгөөнд оруулдаг.) Яагаад гэвэл “бол” гэдгээс “хэрэгтэй” эсвэл “байх ёстой” гэдгийг гаргаж авах боломжгүй байх учиртай. Гэвч, жишээ нь, ургамлын тохиолдол дээр бол, “бол” гэдгээс “хэрэгтэй” гэдгийг гаргаж авч болох нь өчүүхэн ч эргэлзээгүй. Энэ сонирхолтой бөгөөд шинжилж үзэхэд сонирхолтой тохиолдол юм; гэхдээ тийм ч барьцгүй биш. Үүний ач холбогдол нь үл тайлбарлагдах шинжтэй бөгөөд арай илүү тайлбарлагдах шинжтэй баримтуудын хоорондын харилцаанд байх ач холбогдолтой төстэй: энэ харилцааг авч үзсэн нь тун бага. Гэсэн ч “тухайн ургамалд хэрэгтэй” гэдгийг “түүнд юу очсон” гэдэгтэй эсрэгцүүлж болох ч —*de facto*-г *de jure*-д эсрэгцүүлдгийн адилаар—, тэгснээр уг ургамалд тухайн нэг орчин нөхцөл хэрэгтэй гэдгийг “үнэн”-ээс наагуур болгохгүй.

Ургамалд юу хэрэгтэй талаарх тохиолдол дээр, тухайн хүн ургамлыг хөгжин цэцэглүүлэхийг хүсэж байгаа үед л дээрх хэрэгцээний талаарх бодол нь уг хүний үйлдэлд нөлөөлөх нь мэдээж. Энд, тэгэхээр, аливаа хүн тухайн ургамалд юу “хэрэгтэй” талаар шүүн шийдэж болох зүйлс хийгээд түүний хүсэж буй юмсын хооронд зайлшгүй шинжтэй холбоо үгүй. Гэхдээ *таны* өөртөө хэрэгтэй гэж бодож байгаа зүйл хийгээд хүсэж буй зүйл хоёрын дунд нэг төрлийн зайлшгүй шинжтэй холбоос бий. Энэ холбоос нь нэлээд ярвигтай; өөртөө хэрэгтэй хэмээн шүүн шийдсэн зүйлээ *хүсэхгүй* байх боломж байгаа. Гэхдээ, жишээ нь, өөрт хэрэгтэй хэмээн шүүн шийдсэн *ямар ч зүйлээ* хэзээ ч хүсэхгүй байна гэдэг бол боломжгүй. Энэ нь, гэхдээ, “хэрэгтэй байх” гэдэг үгийн утгын талаарх биш, харин *хүсэхүйн* (wanting) феноменоны талаарх баримт юм. Үүний үр дүнд, Хьюмийн сэтгэхүй (reasoning) аливаа хүнийг энэ зүйл “хэрэгтэй байх” эсвэл “сайн байх” үгийн тухайд байх ёстой гэж үзэхэд хүргэнэ хэмээж болох юм.

Ингээд бид нэг талаас баримтуудын “харьцангуй үл тайлбарлагдах шинж”-ийн тухай, нөгөө талд “хэрэгтэй байх,” “хөгжин цэцэглэл” зэрэгт агуулагдсан ухагдахууны талаар тодрууллаа хэмээн үзвэл, “бол” гэдгээс “ёстой” гэдэг рүү хийх шилжилтийн талаарх тайлбарт ороолттой байсан хоёр асуудлыг оллоо —*гэсэн ч* цаана нь гурав дахь онцлох санаа бас бий. Учир нь, Хьюмийг дагаад, хэн нэг хүн ийн хэлж болох юм: Чи “бол” гэдгээс “өртэй” гэдэг рүү, түүнчлэн “бол” гэдгээс “хэрэгтэй” гэдэг рүү хийх шилжилтийн талаарх санаагаа тодруулсан байж болох юм: гэхдээ “өртэй” болон “хэрэгтэй” гэх мэт өгүүлбэрүүд тодорхой *төрлийн* үнэнийг, нэг

төрлийн баримтыг илэрхийлдэг гэдгийг харуулж байж л тэгсэн. Тэгэхээр “бол” гэдэг өгүүлбэрээс “*ёс суртахууны хувьд ёстой*” гэдгийг гаргах боломжгүй хэвээр үлдэж байна.

Надад ийм санал сэтгэгдэл зөв байхаар санагдаж байна. “Ёстой” хэмээх энэ үг, ховсын хүч төдийхний үг болсноор, энэхүү хүчийг агуулж байгаа гэдэг онцлог чанараараа, өөр юунаас гарч ирэх боломжгүй. Үүнийг “ёс суртахууны үүднээс ёстой” гэх бусад өгүүлбэрүүдээс гаргаж болно хэмээн эсэргүүцэж мэдэх юм: гэхдээ тийм зүйл үнэн байж таарахгүй. Тийм мэт харагдах байдал нь бид “Бүх хүн бол ϕ ” бас “Сократ бол хүн” гэдэг нь “Сократ бол ϕ ” гэдгийг илтгэдэг гэж хэлдгээс бий болсон. Гэхдээ энд буй “ ϕ ” гэдэг нь хиймэл предикат юм. Бид жинхэнэ предикатыг “ ϕ ”-ээр орчуулчихвал импликац нь хүчин төгөлдөр байна гэдэг. Жинхэнэ предикат шаардлагатай байна; ухварлагдахуйц (intelligible) бодол огт агуулаагүй зүгээр л үг биш: хүчний зөвлөгөөг тогтоон хадгалсан, бас сэтгэл зүйн хүчтэй нөлөө үзүүлэх хандлагатай боловч жинхэнэ ойлголтыг ердөөс тэмдэглэхээ больсон.

Учир нь үүний зөвлөгөө нь, “ёстой” гэх өгүүлбэрт буй дүрслэлтэй санал нийлж эсвэл зөрснийхөө дагуу, миний үйлдэл дээрх тогтоолын нэг юм. Бас хүн шүүгч эсвэл хууль үгүй хэмээн бодож буй газарт, тогтоол хэмээх ухагдахуун сэтгэл зүйн нөлөөгөө тогтоон хадгалсан ч, утгаа үл хадгална. Одоо “тогтоол” гэх үг л гэхэд уур амьсгалаа тогтоож хадгалсан ч утгаа алдсан байдлаар хэрэглэгдсэн —ёслолын шинж бүхий өргөлттэйгөөр— бас хэн нэг хүн ийн хэлж байна гэж төсөөлье: “Тогтоолын хувьд гэвэл, эцсийн дүндээ, хууль бас шүүгч хэрэгтэй.” Үүнд ийм хариу хэлж болох юм: “Огтхон ч үгүй, учир нь тогтоол өгдөг хууль эсвэл шүүгч байсан бол, тэр тогтоолыг бид хүлээн зөвшөөрөх эсэх тухайд Тогтоол байдаг эсэх нь бидний хувьд асуулт болно.” Энэ бол олон тохиолдолд шийдвэрлэх шинжтэй гэгддэг нэг үндэслэлийн аналог юм: Хэрэв хэн нэг хүн ёс зүйг хууль гэх ойлгоцтой бол, дээрхтэй адилаар, тэр хүн өөрийгөө тэнгэрлэг хуулийг дагах ёстой (ёс суртахууны үүднээс ёстой) гэх шийдэмжтэй гэдэгтэйгээ санал нийлэх учиртай; тэгэхээр түүний ёс зүй өөр бусад ёс зүйтэй яг ижил байр сууринд байгаа: уг хүнд зүгээр л “практик шинжтэй гол нөхцөл (premise)”¹⁷² байна: “Тэнгэрлэг хуулийг дагах ёстой” гэж байхад өөр нэгд нь, жишээ нь, “Хамгийн их аз жаргалын зарчмыг бүх шийдвэрт баримтлах ёстой” гэх нөхцөл (premise) байна.

Би Хьюм болон өнөө бидний үеийн ёс зүйчид “ёс суртахууны үүднээс ёстой” гэх ухагдахуунаас агуулга олох боломжгүй гэдгийг харуулснаараа зохих гавъяа байгуулсан хэмээн шүүн дүгнэх нь зохилтой; хэрэв Хьюмээс хойших үеийн философичид уг нэр томъёоны сэтгэл зүйн хүчийг тогтоож хадгалсан ч орлуулж болох өөр хувилбарыг (тун барьцгүй) хайгаагүй байсан бол. Дээрх ухагдахууныг орхих нь хамгийн үндэслэлтэй юм. Уг ухагдахуунд ёс зүйг хууль гэх ойлгоцоос гадна ямар ч утга учир бүхий утгат чанар (reasonable sense) үгүй; тэд тийм ойлгоцыг хадгалж үлдэхгүй; бас бид үүнгүйгээр ёс зүйг байлгаж болох бөгөөд үүний жишээг Аристотель үзүүлсэн. Хэрэв “ёс суртахууны хувьд буруу” гэдгийн оронд “үнэнч бус,” “задгай/зохисгүй” (unchaste), “зүй бус” (unjust) гэх мэт аймгийг нэрлэдэг болбол их ахиц гарах байсан. Бид ямар нэг үйлдлийн тухай дүрслэлээс шууд уг ухагдахуун руу дамжиж, ямар нэг зүйл хийх нь “буруу” байсан эсэх тухай дахиж асуух хэрэггүй: харин бид тухайн үйлдлийг, жишээ нь, зүй бус байсан эсэх тухай асуувал зохилтой; харин хариулт нь зарим тохиолдолд тэр даруйдаа тодорхой байх болно.

Харин одоо би Сижвикийн төлөөлдөг орчин үеийн Английн ёс суртахууны философийн эрин дээр ирж байна. Миллээс Мур хүртэлх хугацаанд нэгэн гайхал төрүүлэм өөрчлөлт гарсан шиг байдаг. Милл аллага, хулгай гэх мэт үйлдлүүдээс гарах тухайлсан үр дүнгийн талаар тооцоолж үзэхийг асуудал болгох хэрэггүй хэмээн үзэж байсныг харж болно; бас аливаа үйлдэл ашигт

¹⁷² Утгагүй боловч үүнийг ингэж нэрлэдэг. Гол нөхцөл=дүгнэлтэд буй предикат болж буй нэр томъёог агуулж буй нөхцөл учраас, үүнийг практик сэтгэхүйтэй холбож ярих нь таарахгүй.

байдлын талаарх цор ганц зарчим дор хэрхэн орж болох нь ердөө ч тодорхой биш учраас түүний байр суурь муйхар байсныг харж болно. Мур болон түүний ардаас гарсан Английн академик ёс суртахуунч үзэлтнүүд “зөв үйлдэл” гэдэг бол боломжит хамгийн сайн үр дүн авчрах (зарим “Объективистууд”-ын¹⁷³ тодорхой төрөл бүхий үйлдлүүдэд хамаатуулдаг дотоод үнэлэмжийг (intrinsic value) үр дүнгүүд дундаас урьдчилан тооцоод) үйлдэл гэж үзэж байсан нь тодорхой харагдана. Харин үүнээс, субъективээр яривал, хэрэв хүн тухайн нэг нөхцөл байдалд аливаа нэг үйлдлийнхээ бүрэн үр дүн гэж шүүн дүгнэсэн зүйлийнхээ дагуу хамгийн сайны төлөө үйлдэж байгаа бол тэр хүн сайныг хийж байна гэх зүйл урган гарна. Би урган гарна гэж хэлсэн, харин ямар нэг философич яг ингэж хэлсэн гээгүй. Учир нь ийм асуудлуудын талаарх яриа маш нарийн төвөгтэй болж болох нь мэдээж хэрэг юм: жишээ нь, юмс предикаттай байхын тулд оршдог байх учиртай гэдэгт тулгуурлаад, “тийм-тийм үйлдэл бол зөв үйлдэл” гэдэг нь хангалттай сайн томъёолол эсэх тухайд эргэлзэх боломжтой —тэгэхээр хамгийн сайн томъёолол нь “би алба үүрэгтэй” байж магадгүй юм; эсвэл, дахиад, аливаа философич “зөв” гэдэг нь “дүрсэлсэн” (descriptive) нэр томъёо гэдгийг үгүйсгэж, хэл шинжлэлийн задлан шинжилгээгээр дамжуулаад “зөв үйлдэл бол хамгийн сайн үр дүн авчирдаг үйлдэл мөн” гэдэгтэй ижил зүйл бүхий үзэлд (жишээ нь, хүн дагахыг хүссэн зорилгууддаа нөлөө бүхий байлгахаар, “сонголт” ба “хамгийн сайн” хоёрын дундах холбооны үр дүнд тунгаан бодож сонгох гэдэг нь хамгийн сайн үр дагавар авчрах байдлаар үйлдлээ сонгоно гэсэн үг байх тийм байдлаар “зарчмуудаа” хүрээнд оруулдаг) хүргэх тойруу замаар явж болох юм; цаашлаад, “ёс суртахууны зарчим” болон “үүргийн сэдэл” гэгдэх зүйлсийн үүргийг дүрслэх ёстой; “сайн” хийгээд “ёс суртахууны хувьд сайн” болон “зөв” (right) зэргийн ялгааны талаар эрж сурах, “ёстой” гэх өгүүлбэрүүдийн өвөрмөц онцлогийг судлан шинжлэх хэрэгтэй. Үнэхээр ач холбогдолтой зүйл гэвэл бүгдэд нь буй ижил тал байтал дээрх шиг яриа нь үзлүүдийн дунд ач холбогдол бүхий ялгаа байгаа мэтээр харуулдаг. Хэрэв Английн алдарт академик ёс суртахууны философичид, жишээ нь, гэмгүй нэгнийг хороох явдлыг, ямар зорилгын дагуу эсэхээсээ үл хамааран, зөв гэж тооцох боломжгүй бөгөөд үүнтэй зөрж буй хүн бол алдаж байгаа хэрэг болж таарах байдлаар философи гаргаж ирснийг анхаарч үзвэл бүгдэд нь буй нийтлэг шинж тодорхой болно. (Би аль аль санааг нь дурдах учиртай: Жишээ нь, Ноён Хейр гэмгүй нэгнийг хороох нь хамгийн чухал зорилгуудын төлөө аливаа хүний сонгох “ёстой” зүйл байдаг гэж шүүн дүгнэхийг дэмжсэн шинжтэй философи заадаг ч, түүнийхээ хажуугаар бас ийн заах байсан гэж би үзэж байна: хэрэв аливаа хүн гэмгүй нэгнийг “дээд практик зарчим” нь болж буй ямар ч зорилгын төлөө байсан хороохоос татгалзвал, тэр алдаагаа хаацалж үл чадна: тэр нь түүний л “зарчим” юм. Гэвч тийм баталгаагаар, миний дурдсан санааг Сижвикээс хойших Английн бүх л Академик ёс суртахууны философичид хүлээн зөвшөөрч ирсэн нь харагдана гэж бодож байна. Харин одоо энэ бол ач холбогдолтой зүйл юм: учир нь дээрх бүх философийг Еврей-Христийн шашны ёс зүйтэй нэлээд үл авцалдах шинжтэй гэсэн үг болж байгаа юм. Учир нь уг ёс зүй бол ямар үр дагаварт хүргэх эсэхээс үл хамаараад, тодорхой зүйл хориотой болохыг заадаг, жишээ нь: сайн эсвэл өөр ямар ч зорилгын төлөө байсан эсэхээс үл хамаарч гэмгүй нэгнийг хороох сонголтыг хийх; гэмт хүний орон өөр нэгнийг шийтгэх; урван тэрслэх (үүгээр үнэнч нөхөрлөлийн амлалтуудаар амин чухал асуудлын тухайд хүний итгэлийг олсон ч мөнөөх хүнийхээ дайснуудтай нийлж түүнийг мэхлэх гэдэг утгаар хэлэв); шүтээн шүтэх; бэлгийн гаж харьцаа; завхайрал; итгэлийн хуурамч андгай тавих гэх мэт. Тодорхой зүйлсийг зүгээр л тийм-тийм төрлийн үйлдлийг гэх үүднээс, ямар нэг нэмэлт үр дагаврыг үл тооцох байдлаар хорих явдал бол Еврей-Христийн шашны ёс зүй бүхэлдээ биш гэдэг нь тодорхой; гэхдээ бол үүний

¹⁷³ Оксфордын объективистууд “үр дагавар” хийгээд “дотоод үнэлэмж”-ийг ялгаж үзээд, “үр дагаварчлах үзэлтэн” биш мэт хуурмаг үзэгдэх байдлыг бий болгодог. Гэвч тэд, гэмгүй нэгэнд ял оноох нь, жишээ нь, үндэстний ашиг сонирхлоос илүү гарах хэмжээнд хүрч болохгүй гэж үздэггүй —Росс үүнийг онцлон эсэргүүцдэг. Учир нь дээрх зүйлсийн дундах ялгаа тийм ч чухал биш.

чухал нэг шинж мөн; бас Сижвикээс хойших бүх академик ёс суртахууны философичид энэ ёс зүйг үл хамруулах байдлаар бичиж ирсэн бол, энэхүү үл авцалдах байдлыг олж хараагүй явдал болох оюуны түүхий байдал нь уг философичдын талаарх нэг чухал баримт мөн гэдгийг, бас тэдний дунд буй ялгааг харьцуулж үзвэл ялихгүй гэх үндэслэлийг гаргаж ирнэ.

Уг философичдын дундаас хэн нь ч, өөртэй нь зөрчилдөж буй тийм ёс зүй байна гэдгийг ухамсарлаагүйг анзаарч болно: тэд аллагын тухайд байдаг шиг аливаа хориг ямар нэг үр дагаврын өмнө бол хүчингүй байдаг нь илэрхий гэх үзлийг бараг бүрэн хүлээн зөвшөөрч байжээ. Гэхдээ хоригийн хатуу чанд байдал нь *үр дагаврын талаарх найдвар эсвэл айдаст уруу татагдахгүй байлгахад* чиглэсэн санааг бас агуулж байгаа нь мэдээж хэрэг юм.

Хэрэв Миллээс Мур хүртэлх шилжилтийг анзаарсан бол, энэхүү шилжилтийг аль нэг үед, хэн нэгэн хийсэн хэмээн таамаглах болно; Сижвик илүү тохирох нэр шиг санагдана; бас, үнэн хэрэгтээ, түүний үзэлд энэ нь хэвийн зүйл мэтээр явж байгааг олж харах болно. Тэр нэлээд молхи бичдэг байв; бас түүний үзлийн чухал зүйлс нь хөндлөнгийн зүйлсэд, зүүлт тэмдэглэл болон “ёс зүйн арга зүй”-н талаарх их ангилалтай нь хамаагүй жижиг сажиг үндэслэлүүдэд гарч харагддаг. Ёс зүйн талаарх тэнгэрлэг хуулийн онолыг “хамгийн сайн теологичид” (үүгээрээ хэнийг хэлснийг нь тэнгэр бүү мэд) бид Эзэн Тэнгэрийг *ёс суртахуунтай* ахуй (moral being) байх чадамжийнх нь хувьд дагах учиртай гэж хэлдэг хэмээсэн өөр хоорондоо нэг их ялгагдахааргүй зүүлт тэмдэглэлүүд рүү дүйлгэсэн бий. *η φορτικός ο έπαινος*; Аристотель үүнийг “Энэ магтаал бүдүүлэг биш үү?”¹⁷⁴ хэмээн хэлж буйг сонсож байгаа мэт санагдана —гэхдээ Сижвик дараах үүднээс бүдүүлэг байгаа юм: жишээ нь, тэр даруу зан (humility) өөрийнхөө гавъяа зүтгэлийг (merit) доогуур үнэлэх дээр тогтдог гэж үзжээ— өөрөөр хэлбэл, үнэнч шударга биш байх төрөл зүйл дээр; бас Эзэн Тэнгэрийг гутаах явдлын эсрэг хуультай байх суурь нь үүнийг итгэгчдэд халтай гэдэг явдал байсан; бас цэвэр ариун байдлын эрхэм чанарыг заваар судлах нь үүний жаягт (canon) халтай бөгөөд “дундад зууны теологичд” үүнийг анзаараагүй хэмээн түүний буруутгадаг.

Одоо хийж буй шинжилгээний үүднээс үзвэл, Сижвикийн хамгийн чухал зүйл бол сэдэмжид (intention) өгсөн тодорхойлолт нь байв. Тэр, хүн сайн дурын үйлдлийнхээ урьдаас харж болох ямар нэг үр дагаврыг санаж зорьдог гэж хэлэх ёстой болохуйц байдлаар сэдэмжүүдийг тодорхойлсон бий. Энэ тодорхойлолт буруу гэдэг нь мэдээж юм, бас өнөө үед бол хэн ч үүнийг хамгаалахгүй гэдгийг би зоригтойгоор хэлнэ. Тэр өнөө олон хүний хүлээн зөвшөөрдөг ёс зүйн сэдвийг урагш давшуулахдаа уг тодорхойлолтыг хэрэглэжээ: аливаа хүн урьдаас харсан зүйлээ зорилго эсвэл ямар нэг зорилгод хүрэх арга хэрэгсэл болохынх нь хувьд хүсэж эрмэлзээгүй гэдэг нь тухайн хүний хариуцлагатай холбоотой юуг ч өөрчлөхгүй. Сэдэмжийн хэлийг илүү зөвөөр хэрэглэж, Сижвикийн алдаатай ойлгоцоос зайлсхийвэл, дараах сэдвийг дэвшүүлж болно: Санаж зориогүй гэдэг нь аливаа хүн үйлдлийнхээ талаар урьдаас харж болох байсан үр дүнтэй холбоотой хүлээх хариуцлагыг өөрчлөхгүй. Одоо энэ нь нэлээд сургамжтай сонсогдож байна; сургамжтай сонсогддог нь ийм асуудлуудын талаарх нэлээд уналттай үзэл бодлын онцлог гэж би бодож байна. Нэг жишээ авч үзвэл хэр зэрэг гэдгийг нь харж болно. Хэн нэг хүн нэг хүүхдийг асрах үүрэг, хариуцлагатай гэж үзье. Тэгэхээр тухайн хүүхдэд туслахаас албаар татгалзана гэдэг бол түүний хувьд хийх муу үйлдэл болно. Асрахыг хүсэхээ больсон учраас асрамжаа таслан зогсоох нь түүний хувьд муу үйлдэл болно; өөр хэн нэг хүнийг өөр ямар нэг зүйл хийхээс аргагүйд хүргэх учраас больсон гэсэн ч *бас* л түүний хувьд муу байх болно. (Үндэслэлдээ зориулаад тэр хүнээ тухайн нэг зүйлийг хийхээс өөр аргагүй байдалд оруулах нь өөрөө нэлээд гайхалтай хэрэг хэмээн үзэж болох юм.) Харин тэр мундартай үйлдэл хийх эсвэл шоронд орох хоёрын аль нэгийг сонгох учиртай болжээ; хэрэв тэр шоронд орвол, мөнөөх хүүхдээс асрамжаа

¹⁷⁴ E.N. 1178b16

татна гэсэн үг. Сижвикийн номлол ёсоор бол, өөр ямар өөрийнхөө төлөө эсвэл өөр ямар нэг зорилгын төлөө больж байгаа болон мундартай зүйл хийхгүй бол шоронд орох, урьдаас харж болох бас зайлах боломжгүй үр дагавар бүхий нөхцөл байдлаас болоод тэгж буй тохиолдлууд дээр хүүхдийг асрахаа больсонтой холбоотой уг хүнд ирэх хариуцлага нь ялгаагүй байх юм. Үүнээс болоод хүүхдээс асрамжаа салгахын харьцангуй муу чанар хийгээд мундартай зүйл хийхийн харьцангуй муу чанарыг дэнслэх ёстой болно; бас мундартай зүйл хийх нь, үнэн хэрэгтээ, хүүхдийг асрахаа санаатайгаар больсноос бага хорт чанартай гэдэг нь төвөггүй харагдаж байж болно; хэрэв тийм бол хүүхдийг асрахаа больж байгаа нь шоронд орсны дайвар нөлөө болно гэдэг нь уг хүний хариуцлагыг өөрчлөхгүй, ингэж бодож үзэх нь түүнийг мундартай зүйл хийхэд хүргэнэ; тэр мундартай зүйл нь бас л нэлээд муу байх боломжтой. Түүнчлэн, тэр хүн асуудлыг энэ өнцгөөс харж эхэлсэн бол, бодож үзэх учир шалтгаант (reasonable) зүйл нь аливаа үйлдлийн уг чанараараа муу биш харин үр дагавар л болно. Тэгэхээр, түүнийг *их* балаг гаргахгүй хэмээн учир шалтгаантайгаар шүүн дүгнэсэн гэж үзээд, тэр хүүхдийг асрахаа албаар болихоос хамаагүй илүү мундартай зүйл хийж болно. Бас түүний тооцоолол үнэн хэрэгтээ буруу байж таарвал, түүнийг үйлдлийнхээ үр дагаврыг урьдаас тооцоогүй учир хариуцлагагүй байсан болж харагдана. Учир нь, Сижвикийн сэдэв үнэн хэрэгтээ, *урьдчилан хүлээж байсан* үр дагаврын үүднээс л биш бол аливаа үйлдлийн муу чанарыг хэмжих бараг л бололцоогүй болгож байгаа юм. Гэхдээ тийм юм бол, *хүн хүлээж буй* үр дагавруудынхаа үүднээс муу чанарыг хэмжих ёстой; тэгэхээр, хүн хамгийн мундартай үйлдлүүдийн *бодит* үр дагаврыг урьдчилан харж чадаагүй гэдгээ л баталж чадвал өөрийгөө хаацалж болно гэсэн үг болно. Харин би, хүн муу үйлдлийнхээ муу үр дагаврын хариуцлагыг үүрэх боловч сайн үйлдлүүдийнхээ гавъяаг хүртэх ёстой хэмээн тэмцэх учиртай; бас эсрэгээрээ сайн үйлдлийнхээ үр дагавруудтай холбоотой хариуцлага хүлээх ёсгүй.

Лав л хариуцлагыг бодолцож үзэж буй цагт, Сижвик “ёс зүйн арга”-уудаа боловсруулж байхдаа санаж зорьсон хийгээд урьдчилж харсан үр дагавруудын ялгаанд хандсан *ямар ч* үгүйсгэл хийгээгүй байна; тэр энэхүү чухал нүүдлээ бүгдийн нэрийн өмнөөс, уг нүүдлийнхээ өөрийнх нь төлөө л хийжээ; бас би Сижвикийн зүгээс хийсэн *энэ* нүүдэл хуучны-маягийн Утилитар үзэл хийгээд миний *үр дагаварчлах үзэл* (consequentialism) хэмээж буй Сижвик болон түүнээс хойших Английн академик философичдыг онцлох тэмдэг болсон үзлийн дундах ялгааг тайлбарлана гэж хэлэхэд хилсдэхгүй гэж бодож байна. Үүгээр, хуучин уруу татлага (temptation) хэмээн тооцогдож байсан нэг төрөл санал бодолд, хүнд эхнэр болон зусарч нөхдийнх нь шахаж байсан тэр санал бодолд ёс суртахууны философичид онолоороо ач холбогдол өгөв.

Өнгөц философи гэдэг бол үр дагаварчлах үзлийн зайлшгүй нэг шинж юм. Учир нь ёс зүйд завсрын (borderline) тохиолдлууд үргэлж байдаг. Харин та Аристотельч үзэлтэн, эсвэл тэнгэрлэг хуульд итгэгч бол тухайн үйлдлийг тухайн нөхцөл байдалд хийх нь аллага эсвэл зүй бус (injustice) үйлдэл болох эсэхийг бодолцож үзсэнээр завсрын тохиолдлуудыг шийдвэрлэнэ; бас үүнийг тийм эсвэл үгүй тухайд шийдвэр гаргаснаас аа хамаараад, тухайн зүйлийг хийх ёстой зүйл мөн эсэхийг шүүн дүгнэнэ. Энэ үгээр тоглох арга болно; бас энэ нь таныг хязгаар цэг рүү сунахад хүргэж болох ч төвийг үгүй хийлгэхгүй. Харин та үр дагаварчлах үзэлтэн бол, “Тийм-тийм нөхцөлд юу хийх нь зөв бэ?” гэх асуултыг гаргаж тавих нь мунхаг зүйл болно. Үгээр тоглогч бол ийм асуултыг “Тийм-тийм зүйл хийх нь *зөвшөөрөгдөх* үү?” эсвэл “Тийм-тийм зүйл *хийхгүй* байх нь *зөвшөөрөгдөх* үү?” гэх асуултын төлөө л дээрх асуултыг гаргаж тавина. Тухайн зүйлийг хийх нь *зөвшөөрөгдөөгүй* үед л тэр “Үүнийг хийх юм байна” гэж хэлж чадна.¹⁷⁵ Үгүй бол тэр ямар нэг үйлдлийн эсрэг ярьж байсан ч, бодит тохиолдол дээр ямар ч үйлдлийг зааварлаж (prescribe) үл чадна, нөхцөл байдлууд (тухайн хүний төсөөлснөөс давж гарсан) янз бүрийн

¹⁷⁵ Зайлшгүй байх ховор тохиолдол: “Аав, ээж ээ хүндэл” гэх мэт эерэг журмуудын хувьд (precepts) зааварлах нь (prescribe) тун ховор бөгөөд, тодорхой үйлдлийг зайлшгүй болгох нь бүр ч ховор юм.

боломжийг илэрхийлж болох бөгөөд юу юу боломжтойг урьдаас мэдэх аргагүй. Харин үр дагаварчлах үзэлтэнд “Энэ зөвшөөрөгдөнө, энэ нь зөвшөөрөгдөхгүй” гэж хэлэх суурь байхгүй; учир нь түүний өөрийнх таамаглал ёсоор, дээрх асуудлыг үр дагавар нь шийдэх учраас түүнд нэг эсвэл өөр нэг зүйлийг хийснээр ямар эргүүлэг гаргах боломжтой талаар зарчим гаргаж чадах мэтээр дүр эсгэх хэрэг байхгүй; тэр хамгийн сайндаа ийн хэлж болно: хүн тийм эсвэл тийм үр дүнг авчирч болохгүй; бодит тохиолдол дээр бол тэр тийм-тийм зүйлийг хийхгүй л бол тийм-тийм үр дагавар авчирна гэж хэлэх эрх байхгүй. Цаашлаад, үр дагаварчлах үзэлтэн завсрын тохиолдлуудыг төсөөлье гэвэл, тухайн ямар нэг хууль эсвэл жишигт тулгуурлаж тухайн тохиолдлыг завсрын тохиолдол хэмээн үзэх ёстой нь мэдээж хэрэг. Харин энэ жишгээ тэр хаанаас авах вэ? Бодит үйлдэл дээр бол хариулт нь дараахаас өөрөөр байхгүй: нийгэм эсвэл хүрээлэл дунд нь, тухайн үед буй жишгээс авна. Бас үнэн хэрэгтээ энэ нь энэ философичдыг тун хэвшмэл (conventional) байж ирсний тэмдэг мөн; тэдэнд өөрсөд шигээ хүмүүсийн дунд хэвшсэн жишгийн өөдөөс босох юу ч байгаагүй; гүн гүнзгий байна тэдэнд боломжгүй байлаа. Гэвч хэвшсэн жишиг нь бүхэлдээ дөмөг байх боломж бага. Эцэст нь, таамаглалын нөхцөл байдлуудыг, магадгүй тохиолдох боломж тун багатайг нь, төсөөлж үзэхийн гол зорилго нь өөрийгөө эсвэл өөр хэн нэгнийг таамаглалын шинжтэй ямар нэг төрлийн муу зүйл хийх эсэхийг олж мэдэх явдал *шиг байдаг*. Тухайн төсөөлж үзсэн гарах гарцгүй нөхцөл байдал огтоос биелж гарахгүй байгаа үед, бөөн хүн дараах зүйлсийг хийж байгаа цагт, энэ нь хүмүүсийг — таамаглалын шинжтэйгээр сонголт хийсэн тэр нөхцөл байдалдаа хэзээ ч орохгүй — төстэй муу үйлдлүүд дээрээ зөвшилцөхөд, эсвэл тэрхүү үйлдлийг хийж буй улсыг сайшааж эсвэл зусардахад хүргэж болно гэдэгт эргэлзэхгүй байна.

“Алба үүрэг” болон эмпатик, “ёс суртахууны,” *ёстой* гэх ухагдахуунууд ёс зүйг тэнгэрлэг хууль гэх ойлгоцоос гаралтай гэдгийг анзаарсан ч тэнгэрлэг хууль тогтоогчийн тухай ухагдахууныг үгүйсгэгч хүмүүс заримдаа тэнгэрлэг хууль тогтоогчгүйгээр ёс зүйг хууль гэх ойлгоцыг хадгалж үлдэх боломж эрдэг. Энэхүү эрэл тодорхой ашиг сонирхолтой гэж би бодож байна. Магадгүй хамгийн түрүүнд өөрийгөө санал болгох зүйл нь аливаа нэг нийгмийн “хэм хэмжээ” (norms) байх. Гэхдээ мөс чанар нь (conscience) хүнд ямар зүйл хийхийг хэлж болох талаар тунгаан бодох үед Батлер гүн сэтгэгдэл төрүүлэхгүй шиг, нийгмийн “хэм хэмжээ” ямар байж болохыг тунгааж үзвэл дээрх үзэл ч бас гүн сэтгэгдэл төрүүлэхгүй. “Өөрөө өөртөө” хууль өгч болно гэдгийг би утгагүй хэрэг хэмээн үзэж, татгалзаж байна; “өөрийнхөө төлөө” хийсэн юу ч биширмээр байж болно; гэхдээ энэ нь хууль тогтоохгүй. Нэгэнт үүнийг олж харсан бол, ийн хэлж болох юм: Би өөрийнхөө дүрмийг хүрээлж гаргах ёстой, эдгээр нь миний гаргаж болох хамгийн сайн дүрүүд болохоор би ямар нэг илүү дээр зүйлийг олж мэдэх хүртлээ эдгээрийн дагуу явах хэрэгтэй: хүн “Би өвөг дээдсээс ирсэн заншлын дагуу явна” гэж хэлж болохын адилаар. Энэ нь сайн эсвэл хорон муу өөд хөтлөх эсэх нь тэрхүү дүрэм эсвэл өвөг дээдсээс ирсэн заншлын *агуулгаас* хамаарна. Үүнд бол тийм хандлага их бага хэмжээгээр найдвар тээнэ: өмнөхөөсөө ухарч ийм арга хэрэгсэлд хандах үед, үүнд тодорхой Сократч эргэлзээ гарч байгаа харагдах бөгөөд Сократч эргэлзээ сайн гэдэг нь тодорхой байх учиртай; үнэн хэрэгтээ, нэлээд ерөнхий байдлаар, энэ нь “Магадгүй би аль нэг талаас өөрийгөө муу замаар явж байгаагаа харж чадахгүй байгаа байх, магадгүй би ямар нэг амин чухал зүйл дээр аргагүй буруу байгаа байх” хэмээн бодох хэнд ч сайн байх учиртай. —“Хэм хэмжээ”-ний эрэл нь ертөнцийг хууль тогтоогч хэмээн үзэж байгалийн хуулийг эрэхэд хүргэж болно; гэхдээ өнөө үед бол энэ нь сайн үр дүнд хүргэх хандлага багатай байна: байгалийн хуулийн дагуу хүчтэй нь сул доройгоо идэхэд хүргэж болох ч зүй ёсны (justice) тухай ухагдахуунууд руу бол бараг л хөтлөхгүй; Зүй ёсыг юмсыг ажиллуулж буй тэнцвэр, зохицолтой харьцуулж болохуйц байдлаар үзэх Сократаас-урьдач үеийн сэтгэгдэл өнөө биднээс алсарчээ.

Энд дахиад нэг боломж бий: “алба үүрэг” гэрээнээс бий болсон байж болно. Бид хууль дор буй хүн хуулийн дагуу юу хийх шаардлагатайг хуулиас харж болохтой адилаар, аливаа гэрээг хийсэн хүн юу хийх шаардлагатайг гэрээнээс харж болно. Сэтгэгчдэд, хүмүүсийн мэддэгчлэн биднээс алсуур, *foedus rerum*-ын тухай, хууль тогтоогч биш харин гэрээний биежилт болох ертөнцийн талаарх санаа байж болох юм. Тэгвэл гэрээ нь юу байсан талаар олж мэдэж чадвал, түүний доорх алба үүргийнхээ талаар мэдэж болно. Харин, хуулийг хүнд тунхаглаагүй л бол тэр хүн хуулийн дор байх аргагүй; бас “байгалийн тэнгэрлэг хууль”-д итгэдэг сэтгэгчид уг хуулиа сайн хийгээд хорон муугийн талаарх мэдлэгтэй, том болсон хүн бүрд тунхаглагдсан гэж үздэг. Үүнтэй ижлээр, гэрээ байгуулаагүй бол, өөрөөр хэлбэл гэрээнд гарын үсэг зураагүй бол гэрээний дор байж таарахгүй. Зүгээр л нэг боломж байгааг дурдахад,

Хүн жирийн амьдралын авир үйл дундах хэлний хэрэглээгээрээ, тодорхой нэг үүднээс, өөр өөр гэрээнд орох гарын үсэг зурдаг хэмээн маргаж болох юм. Хэрэв хэн нэг хүн ийм онолтой байвал, бид энэ асуудлыг шийдвэрлэж байгаа эсэхийг харахыг хүсэх учиртай. Энэ нь олон талаар формаль шинжтэй байж таарах болов уу; хуулийг биежүүлж буй тогтолцоог байгуулах боломжтой байж болно (байр суурийг нь логикийн “хуулиуд”-тай харьцуулж болох): “эм галууны маханд таардаг сүмс эр галууны маханд таарна,” гэхдээ аллага эсвэл бэлгийн гаж харьцааны талаарх тухайлсан зүйлсэд хүрэх нь юу л бол. Түүнчлэн, хүн өөрийнхөө хууль хэмээн бодоогүй, хууль гэж хүлээн зөвшөөрөөгүй хуулийнхаа дор байж болох нь тодорхой боловч гэрээнд бол өөрөө мэдэлгүйгээр орж болно гэж хэлэх нь учир дутагдалтай санагдаж байна; тийм тоомсоргүй байдал дийлэнхдээ бол гэрээний уг чанарыг эвдэж таардаг.

Энэ үзэл “хэм хэмжээ”-г хүний эрхэм чанаруудаас эрсэн хэвээр үлдэж болох юм: хүнд байдаг дундаж тооны шүдтэй тэнцүү биш боловч уг төрөл зүйлд хамаарах тооны шүдтэй хүн байж болдог, магадгүй тэгэхээр хүн гэх төрөл зүйлийг, зөвхөн биологийн үүднээс биш давхар өөр өөр амьдралын салбаруудад —хүч, тоног болон хэрэгцээт зүйлсийн хэрэглээ— хамаарах сонголт болон бодох үйл ажиллагааны үүднээс тийм-тийм эрхэм чанартай “байдаг” хэмээн авч үзэх учиртай: бас, жишээ нь, бүрэн шүдтэй хүн “хэм хэмжээ” (norm) болдог шиг эрхэм чанаруудын бүрэн цогц бүхий энэ “хүн” хэм хэмжээ болно. Гэхдээ энэ үүднээс бол “хэм хэмжээ” гэдэг нь “хууль” гэдэгтэй эв хавьгүйгээр тэнцүү байдгаа больсон байна. Энэ үүднээс “хэм хэмжээ” гэх ухагдахуун бидэнд ёс зүйн талаарх хуулийн шинжтэй биш, харин Аристотелийн ойлгоцыг ойртуулжээ. Үүнд ямар нэг уршигт зүйл байхгүй хэмээн би бодож байна; гэхдээ хэн нэгэн “хэм хэмжээ” гэдэгт утгат чанар оноохоор энэ зүгт харсан бол, тэр хүн “Эзэн Тэнгэргүй хууль” гэхийг хүсэж байсан тэр ухагдахуун нь “хууль” гэдгийг илтгэхээ больсон гэдгийг, “хэм хэмжээ” гэх ухагдахуунд юу тохиосон талаар ухаарсан байх ёстой; тэгэхээр, хэрэв дөнгөвөл, “ёс суртахууны алба үүрэг,” “ёс суртахууны үүднээс ёстой,” болон “үүрэг” зэрэг ухагдахуунуудыг бас жагсаалтдаа нэмэх нь зохимжтой байна.

Гэхдээ энэ дундуур, сэтгэл судлалын философийн хэсэг болохынх нь хувьд л судлан шинжлэх хэрэгтэй хэд хэдэн ойлголт байгаа нь, бас би *ёс зүйг санаанаасаа ор мөргүй арилгахыг* санал болгох ёстой гэдэг нь тодорхой биш байна гэж үү? Тухайлбал —эхнээсээ: “үйлдэл,” “сэдэмж,” “таашаал,” “хүсэхүй.” Эцэстээ “эрхэм чанар” гэх ойлголтыг авч үзэх хүртэл урагшилж болох юм; үүгээр бид нэг төрөл зүйлийн ёс зүйн судалгаа эхлүүлж байх учиртай гэж би бодож байна.

Би “ёстой” гэх үгийг өвөрмөц “ёс суртахууны” утгат чанараар бус харин эмпатик-бус маягаар хэрэглэхийн; “ёс суртахууны” утгат чанар бүхий “буруу” гэх үгийг орхиж, “зүй бус” (unjust) гэх мэт ухагдахуунуудыг хэрэглэхийн давуу талыг дүрсэлснээр өндөрлөө.

Хэрэв аливаа хүн жишээ гаргаснаар л цааш явах боломжтой бол, уг чанараараа зүй бус (unjust) бас тухайн нөхцөл байдлаасаа хамаараад зүй бус болох зүйлсийг ялгах боломжтой. Аливаа хүнийг хийгээгүй гэдэг нь илэрхий байгаа хэргийн төлөө түүнийг тангарагтны шүүхээр оруулан шийтгүүлэх хугацааг нь тогтооно гэдэг бол уг чанараараа зүй бус юм. Үүнийг хийж болох нь

мэдээж хэрэг, бас янз бүрийн арга замаар ихэнхдээ хийсээр ч ирсэн; хахууль өгч хуурамч гэрч оруулах, баримтаас үзвэл үнэн биш гэдэг нь илэрхий байгаа хэргийг үнэн “гэж үзсэнээр” хуулийн дагуу, бас шүүгчид бас эрх мэдэлтэй хүмүүсийн талаас ил эсвэл далд байдлаар “Чи үүнийг хийгээгүй гэдэг баримт бол дэмий зүйл; яасан ч бай бид чамайг яллана гэсэн үг” гэх утгатай зүйл хэлж буй үл ойшоолоор. Жирийн нөхцөлд бол, зүй бус гэдэгт, жишээ нь, хүнээс харагдах өмчийг (ostensible property) нь хуулийн шатны дамжлагагүйгээр салгах, өрөө төлөхгүй байх, гэрээгээ дагахгүй байх болон эдгээртэй төстэй олон зүйлс байж болно. Харин нөхцөл байдлууд эдгээр шиг үйл явцыг зүй бос эсвэл зүй ёсны хэмээн үнэлэхэд ихээхэн өөрчлөлт оруулж болох нь илэрхий; бас энэ нөхцөл байдлууд зарим тохиолдолд тухайн хүн тохионо гэдгийг нь урдаас тооцож үзсэн үр дагаврыг агуулж болно; жишээ нь, ямар нэг зүйлийг өмчлөх талаарх мэдэгдэл нь тухайн зүйлийг хэн нэгэн булаах эсвэл хэрэглэх явдал нь илэрхий гамшигт үр дагавраас сэргийлэх боломжтой үед бол хүчингүй болно: жишээ нь, тэр хүний машиныг дэлбэлэхүйц байдлаар хэрэглэсэн ч, тэгснээрээ үерийн усыг зайлуулах эсвэл гал давж орохооргүй зай гаргаж болохоор байсан бол. Харин одоо уг чанараараа зүй бус биш, харин ердийн үед зүй бус байж болох үйлдэл илүү дээр үр дагаврыг учир шалтгаантайгаар тооцоолсны үр дүнд ямагт зүй ёсны хэмээн тооцогдож болно гэсэн үг биш гэдэг нь илэрхий байна; үүнээс хамаагүй хол; гэхдээ зааглах зураас (эсвэл зааглах бүс) татах гэсэн оролдлого дунд үүсэх асуудлууд бол ярвигтай байна гэдэг нь мэдээж юм. Түүнчлэн энд хэлэх учиртай зарим ерөнхий тайлбар байгаа нь, татаж болох тодорхой зааг байгаа нь тодорхой боловч тухайлсан тохиолдлууд дээр гаргах шийдвэр дийлэнх талаараа *κατά τὸν ὀρθὸν λόγον* “юу учир шалтгаантай байгаагийн дагуу” (according to what is reasonable) гарна. —Жишээ нь, *тийм-тийм* төрлийн өртэй хүн тухайлсан нэг нөхцөлд байдалд орсны улмаас төлөлтөө *тэгж-тэгж* хойшлуулахад хүрсэн бол уг хүн тийм байдалд орсон нь зүй ёсны дагуу эсвэл зүй бус болох эсэх нь “юу учир шалтгаантай байгаагийн дагуу” л шийдэгдэх юм; бас үүнд, *зарчмын үүднээс* бол цөөн хэдэн жишээ өгөхөөс өөр жаяг (canon) байх аргагүй. Өөрөөр хэлбэл, философид буй том зайнаас болоод эрхэм чанар хийгээд зүй ёс гэх ойлголтуудад ерөнхийлсөн тайлбар хийх аргагүй ч гэлээ бид жишээ гаргах замаар л, уг ойлголтуудыг хэрэглэж урагшлах учиртай; гэсэн ч ямар нэг жишээ ашиглан тайлбарлахаас өөр аргагүй хоосон зайнаас болоод биш, харин зарчмын үүднээс тайлбар хийх хүрээний асуудлууд бий: энд л аливаа жаяг нь “учир шалтгаантай зүйл” болж байгаа юм: гэхдээ энэ жаяг *биш* гэдэг нь мэдээж билээ.

Зарим нөхцөлд зүй ёсны болдог, заримд нь зүй бус болдог зүйлсийн талаар бас урьдаас тооцож хүлээсэн үр дагаврууд юу зүй ёсны болохыг тогтооход ямар үүрэг гүйцэтгэж болох тухайд үүнийг л хэлэхийг хүссэн. Уг чанараараа зүй бус (intrinsically unjust) зүйлсийн талаарх жишээ рүүгээ эргэн ороход: хэрэв тухайн нэг хүн тухайн хэргийг хийгээгүй гэдгийг бүрэн дүүрэн ойлгосон хэр нь тангарагтны шүүхээр шийтгэх явдлын тухай ярьж байгаа бол, үүнийг зүй бус хэмээн дүрслэхийн эсрэг үндэслэл огтоос үгүй. Тухайн хэрэг явдлыг хэрэг хийгээгүй гэдэг нь мэдэгдсэн хүнийг тангарагтны шүүхээр шийтгэж байна гэх дүрслэлийг өөр болгохгүй байгаа ямар ч нөхцөл байдал, урьдаас тооцоолж хүлээж байсан ямар ч үр дагавар уг хэрэг явдлыг зүй бус хэмээх дүрслэлийг засаж үл чадна. Үүний эсрэг заргалдахыг завдсан хүн бол “зүй бус” гэх үг юу гэсэн утгатай болохыг мэдэхгүй царайлж байгаа л болж таарах болно: учир нь дээрх хэрэг бол зүй бус байдлын парадигм жишээ (paradigm case) мөн.

Энд бид “зүй бус” гэх нэр томъёо “ёс суртахууны үүднээс зөв” болох “ёс суртахууны үүднээс буруу” гэх мэт нэр томъёоноос дээгүүр байгааг харлаа. Учир нь Сижвикээс хойших Английн ёс суртахууны философичдын хам сэдвийн хүрээнд бол дээрх хэрэг явдал зарим нөхцөл байдалд бол “ёс суртахууны үүднээс зөв” байж болох эсэх талаар хэлэлцэж болох аж; гэвч дээрх шиг хэрэг явдлыг ямар ч нөхцөл байдалд зүй ёсны байна хэмээн үндэслэх арга үгүй.

Одоо би үүнд холбогдох философийг гаргаж чадахгүй нь, —бас өнөөгийн Английн философийн нөхцөл байдал дунд буй ямар ч философи үүнд холбогдох философийг гаргаж *чадна* гэж бодохгүй байна— гэхдээ сайн хүн гэдэг бол зүй ёстой хүн гэдэг нь тодорхой; харин зүй ёстой хүн гэдэг бол ямар нэг үр дагавраас болоод, нэг бол өөртөө эсвэл өөр хэн нэгэнд ямар нэг давуу тал олж авахын тулд зүй бус үйлдэл хийхээс татгалзаж дадсан хүн юм. Үүнтэй хэн ч санал зөрөхгүй ч байж болох. Гэхдээ, зүй бус зүйлийг заримдаа урьдаас тооцоолж, хүлээж байсан үр дагавраар тогтоож болно хэмээж болох юм; бас энэ гарцаагүй үнэн. Гэхдээ тийм биш байх тохиолдлууд ч бий: хэн нэг хүн “би санал нийлж байна, гэхдээ энэ бүхэнд их тайлбар хэрэгтэй” гэж хэлсэн гэвэл, түүний зөв болохоор барахгүй, одоо байгаа нөхцөл байдалд бид тэрхүү тайлбарыг хийж чадахгүй; бидэнд философийн зэмсэг дутаж байна. Гэхдээ аливаа хүн үнэхээр *давшин* сэтгэж,¹⁷⁶ гэмгүй нэгнийг тангарагтны шүүхээр оруулж цаазлах гэх мэт үйлдлийг бид бодолцож үзэлгүй орхих эсэх тухай асуудал нээлттэй байна хэмээн бодож байвал —надад түүнтэй маргах хүсэл алга; тэр бурангуй оюун санааг харуулж байна.

Тийм тохиолдлуудад бол манай ёс суртахууны философичид бидэн дээр диллем тохоох гэнэ. “Хэрэв ‘зүй бус’ гэх нэр томъёо цэвэр баримтын дүрслэл болохынхоо хувьд хэрэглэгдэж байгаа тийм тохиолдол байвал, хүмүүс зарим тохиолдолд зүй бус зүйл хийхээс аргагүй болсон нь ойлгогдохуйц байж болох эсэх тухай асуудал дэвшүүлж болохгүй гэж үү? Хэрэв ‘зүй бус болж буй зүйл’ нь тийм-тийм нөхцөл байдалд, тэгж-тэгж үйлдэх нь *зөв* эсэх тухай бодолцож үзсэний дүнд тогтоогддог юм бол, ‘буруу’ гэдэг нь зүй бусын тодорхойлолтод багтсан гэдгээс л болоод зүй бус зүйл хийх нь ‘зөв’ эсэх тухай асуудал гарч ирэхгүй. Гэхдээ бидэнд ‘буруу’ гэдгийг дотроо оруулаагүй, ‘зүй бус’ гэдэг дүрслэл зөвхөн баримт болохынхоо хувьд хэрэглэгддэг тохиолдол байвал, аливаа хүн зүй бусыг үйлдэх ёстой болж магадгүй эсэх тухай, энэ нь ‘зөв’ биш байж болох эсэх тухай асуулт гарч ирж болно. Бас ‘ёстой’ болон ‘зөв’ гэдгийг энд *ёс суртахууны* утгаар хэрэглэж байгаа нь мэдээж хэрэг юм. Одоо бол та *өөр* тодорхой ‘зарчмууд’-ын дор юу ‘ёс суртахууны үүднээс зөв’ болохыг шийдэх ёстой, эсвэл энэ талаар ‘зарчим’ гаргаж зүй бус зүйл хэзээ ч ‘зөв’ байхгүй хэмээн шийдэх учиртай; гэхдээ удаахыг нь хийсэн байлаа ч, баримтаас хальж гарах болно; та өөрөө өөрийнхөө хийхгүй шийдвэрийг гаргаж байна, эсвэл зүй бусыг үйлдэх нь буруу байна. Гэхдээ аль ч тохиолдолд, ‘зүй бус’ гэх нэр томъёог зөвхөн баримт л тогтоож байгаа бол, ‘буруу’ гэх үг хамаатай эсэхийг ‘зүй бус’ гэх нэр томъёо бус, зүй бус зүйл бол *буруу* гэх шийдвэр, ‘баримтын шинжтэй’ дүрслэлээс зүй бус гэх дүгнэлт гарч байна гэх оноштой хамт тогтооно. Гэхдээ зүй бус зүйл бол ‘буруу’ хэмээн туйлын шинжтэй шийдвэр гаргаж буй хүнд, уг шийдвэрийг гаргаагүй хүнийг алдаатай үнэлж дүгнэж байна хэмээх шүүмжийг хийхэд нь гишгэх суурь үгүй.”

Энэ үндэслэл дээр “буруу” гэдгийг “ёс суртахууны үүднээс буруу” гэдэг утгаар тайлбарлаж байгаа нь мэдээж, бас уг нэр томъёоны хамаг л уур амьсгал нь хадгалагдаж үлдсэн боловч гол утга нь ач холбогдлоо нэлээд алджээ. Одоо “ёс суртахууны үүднээс буруу” гэдэг бол “цээртэй,” эсвэл “хийхгүй байх алба үүрэг бүхий” гэх мэт ойлголтын залгамж халаа мөн гэдгийг санацгаая; эдгээр ойлголтууд ёс зүйн талаарх тэнгэрлэг хуулийн онолд хамаарна. “Зүй бус” зүйлийг хийхгүй байх алба үүрэг бий гэж хэрэх нь “зүй бус” гэх дүрслэлээр үнэхээр юм нэмж байгаа

¹⁷⁶ Хэрэв тэр бодит нөхцөл байдал дээр ийн бодож байгаа бол, тэр жирийн л нэг уруу татагдсан хүн байж таарах нь мэдээж. Энэ өгүүллийг уншиж танилцуулж байх үед гарсан хэлэлцүүлэг дунд, магадгүй угаас гарна хэмээн хүлээж байж ч болох байсны дагуу, дараах тохиолдлыг гаргаж ирсэн: засгийн газар нэг гэмгүй хүнийг “ус төрөгчийн тэсрэх бөмбөгийн дайн”-ы аюул гэх хэргийн дор шүүж, яллаж, цаазлах шаардлагатай болжээ. Тийм хүмүүсийн заналхийлж буй дайнаас сэргийлэх явдал ийм шаардлагад хүргэнэ гэвэл надад сонин санагдана. Гэхдээ хэлэлцүүлэг дунд иймэрхүү тохиолдол гаргаж ирэхийн хамгийн чухал зүйл нь хоёрхон чиг шугам л боломжтой гэх үзэл юм: энд бол, дагаж буулт хийх болон ширүүн эсэргүүцэх хоёр сонголт. Тийм нөхцөлд ямар ямар боломжууд байхыг хэн ч урьдаас хэлж мэдэхгүй.

хэрэг болно; учир нь алба болж буй зүйл бол тэнгэрлэг хууль мөн —тоглоомд дүрэм алба болдогтой адилаар. Тэгэхээр тэнгэрлэг хууль нь зүй бусыг хорьсноор зүй бусыг үйлдэхгүй байхыг алба үүрэг болгодог бол, “зүй бус”-ыг үйлдэхгүй байх алба үүрэг бий гэж хэлэхийн тулд “зүй бус” гэх ойлголт дээр яах аргагүй юм нэмж байна. Бас “ёс суртахууны хувьд буруу” гэдэг нь уг дээрх ойлголтын залгамж халаа болохоор биш харин урган гарсан бүл ойлголтуудаасаа тасарч хоцорсон залгамж халаа нь учраас “ёс суртахууны хувьд буруу” гэдэг нь “зүй бус” хэмээх зүгээр л баримтын шинж бүхий дүрслэлээс хальж байгаа бөгөөд миний цэвэр сэтгэлзүйн хэмээн тодотгох тодорхой давагдашгүй хүчнээс өөр ялгарах агуулгагүй болж байгаа юм. Харин тэр нь тэнгэрлэг хуулийн тухай ухагдахууныг авч ашигласан ч амин чухал өөрчлөлт авчрахгүй учраас үүнийг орхиж болно хэмээн үздэг тэр нэр томъёоны хүч юм —учир нь тэд “Би тэнгэрлэг хуулийг дагах ёстой (би ёс суртахууны хувьд алба үүрэгтэй)” гэдгийг ажиллуулж буй “практик зарчим” нь тэнгэрлэг хуульд итгэдэг хүнд шаардлагатай хэмээн үздэг. Гэтэл үнэн хэрэгтээ алба үүргийн талаарх энэ ухагдахуун болбоос хуулийн хам сэдвийн хүрээнд л үүргээ гүйцэтгэдэг ухагдахуун мөн. Бас би өнөө үеийн ёс суртахууны философичид “ёс суртахууны үүднээс ёстой” гэх нэр томъёоны уур амьсгалыг авч үлдэх хорсолтой хүсэл эрмэлзэл гаргахгүй бол уг нэр томъёоны хуурмаг төрх бүхий агуулгыг салгаж авсанд нь баяр хүргэхийг хүсэж байна.

Хэрэв бид “ёс суртахууны үүднээс ёстой” гэх ухагдахууныг орхиж, ердийн л “ёстой” гэдэг рүү буюу аваад хаячихсан байна гэж төсөөлөхөд ч бэрх гэдгийг нь бидний анзаарах ёстой, хүний хэлэнд байнга хэрэглэгддэг тэрхүү нэр томъёо руу эргэхдээ шийдмэг байж чадвал дээрх нь боломжтой байж болно. Харин бид үүн рүү эргэсэн бол, аливаа хүн хэзээ нэг цагт зүй бусыг үйлдэх хэрэгтэй болж болох эсэх, эсвэл зүй бус зүйл нь аливаа хүний хувьд хийж болох хамгийн сайн зүйл нь болж болохгүй юу гэх мэтийг учир шалтгаантайгаар асууж болно. Мэдээж хэрэг тэгж болно. Бас үүнд өгөх хариулт олон янз байна. Нэг хүн —философич— зүй ёс бол эрхэм чанар (virtue), зүй бус нь хорт чанар учраас (vice), бас эрхэм хийгээд хорт чанарууд нь илэрч буй тухайлсан нэг үйлдлийн гүйцэтгэл дээр босож ирдэг учраас, зүй бус үйлдэл нь хүнийг муу хүн болгох хандлагатай байна; бас хүн хүн болохынхоо хувьд хөгжиж цэцэглэх явдал нь амин чухал талаараа түүний сайн байх (эрхэм чанарын хувьд) эсэхээс хамаарна; гэвч тийм нэр томъёо үйлчлэх ямар ч Х-ийн хувьд, тэр Х-д өөрийг нь хөгжин цэцэглүүлэх зүйл хэрэгтэй, иймд хүн эрхэм чанар бүхий үйлдлийг гүйцэтгэх хэрэгтэй эсвэл ёстой; бас зүй бусыг үйлдэхгүй байснаар амин чухал биш зүйлсээрээ бага хөгжин цэцэглэсэн, эсвэл огтоос хөгжин цэцэглээгүй байж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой ч гэлээ, зүй бусаас зайлсхийгээгүйн улмаас амин чухал хүрээндээ гашилна —иймд тэр зүй ёстой үйлдэл гүйцэтгэх хэрэгтэй хэвээр үлдэнэ. Платон, Аристотель нар иймэрхүү зүйл ярьж байв; гэхдээ философийн хувьд, өнөө бидний үзэж байгаагаар дүүрэх аргагүй, том зай гарсныг харж болох бөгөөд, үүнийг хүний уг чанар, хүний үйлдэл, эрхэм чанар болох хэв шинж бүхий онцлог болон хамгийн гол нь хүний “хөгжин цэцэглэл”-ийн талаарх тайлбараар дүүргэх учиртай. Бас энэхүү сүүлийн ойлголт хамгийн эргэлзээтэй харагдана. Учир нь өвчин хийгээд өлсгөлөн, ядууралд өртсөн, найз нөхөргүй хүний хувьд “хөгжин цэцэглэл” арай л хол гэдгийг Аристотель өөрөө хүлээн зөвшөөрсөн бий. Цаашлаад, аливаа хүн “хөгжин цэцэглэх”-ийн тулд ядаж л амьд байх хэрэгтэй шүүдээ хэмээн хэлэх хүн гарч мэдэх юм. Өөр нэгд нь дээрх бүгд нөлөө үл өгөн “Бидэнд тийм-тийм зүйл хэрэгтэй, бид ийм зүйл (тэр нь зүй бус) хийхгүй байна гэж үгүй —тэгэхээр бид үүнийг хийх ёстой” хэмээн зөрүүдээр хэлэхэд хүргэж болно. Философичдын нарийн боловсруулсан сэтгэхүйг дагахгүйг илүүд үзэх өөр нэгэн нь зүгээр л “Хүн зүй бусыг үйлдэх нь дээр гэж хэлэх явдал ямар ч тохиолдолд мундартай зүйл болно гэдгийг би мэднэ” гээд хэлж байж болно. Тэнгэрлэг хуульд итгэдэг нэгэн “Ингэх хориотой, зүй бусыг үйлдэх нь ашигтай санагдаж байж болох ч хэнд ч ашиг тус өгөхгүй” гэж хэлж мэдэх юм; тэр хүн Грек философичдын адилаар “хөгжин цэцэглэхүй”-н үүднээс бодож бас болно. Хэрэв тэр стойк бол, “хөгжин цэцэглэл” юунаас “тогтох” тухайд

нэлээд чанга ухагдахууныг баримтлахаар шийдэх хандлагатай байна; хэрэв тэр Еврей эсвэл Христийн шашинтай нэгэн бол, түүнд хөгжин цэцэглэлийн талаарх тусдаа ухагдахуун хэрэггүй: зүй бусаас зайлсхийх явдлаас ирэх ашиг тус нь түүний хувьд Бурханы шийдвэрт үлдээгээд, өөрөө өөртөө “түүний хуулийн эсрэг үйлдэх нь надад ямар ч тус авчрахгүй” хэмээнэ. (Гэхдээ тэр бас сүүлд ирэх шинэ амьдралд агуу их шагналыг найдан хүлээнэ, жишээ нь Мессиаг ирэх үед; гэхдээ энэ тохиолдолд бол тэр онцгой амлалтад түшиглэж байна.)

“Бидэнд тийм-тийм зүйл хэрэгтэй, бас үүнийг зөвхөн ийм замаар л олж авна” гэж хэлдэг хүний үгээр тогтолцоо босгох явдал эрхэм чанарын зан байдал байж болох эсэх асуудал орчин үеийн ёс суртахууны философид —Сижвикээс хойших хамаг л алдарт ёс зүйчдийн боловсруулсан ёс суртахууны философи— үлдэж байна: өөрөөр хэлбэл, гэмгүй нэгнийг тангарагтны шүүхээр шийтгэх гэх мэт хэрэг явдал зарим тохиолдолд “зөв” байж болох эсэх тухай асуултын хариу нээлттэй хэвээр үлдэж байна; бас өнөөгийн Оксфордын ёс суртахууны философицид тийм зүйл хийхгүй байхыг “өөрийнхөө зарчим болгох” *зөвшөөрлийг* соёрхдог боловч, юу хийх талаар маргаж байсан хүн тийм үйлдлийн тодорхой үр дагаврыг “ёс суртахууны үүднээс” авч үзэж болно гэх философийг заадаг; бас тэд тухайн хүний “зорилгууд”-тай зөрчилдсөн бол, энэ нь тухайн хүн мөнөөх үйлдлээ гаргаж “дөнгөсөн” (ноён Новелл-Смитийн хэллэгийг ашиглавал) ёс суртахууны зарчмынхаа хүрээг тогтоох нь түүний ёс суртахууны боловсролд нэг алхам болж мэднэ; эсвэл энэ нь тийм-тийм нөхцөл байдалд гэмгүй нэгнийг тангарагтны шүүхээр яллахад хүргэх ёстой эсэхийг шийдэх тухайд түүний ёс суртахууны сэтгэлгээний хэлбэржилтэд дэвшил бий болгож буй шинэ “шийдвэрийн зарчим” (ноён Хейрийн ойлгоцыг хүлээн авахад) байж болно. Би мэдүүлэх гомдол ингээд дуусаж байна.